



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2020.08.27 № 295

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ ДААН
НЭР ДЭВШИГЧ П.ДАВХАРБАЯР
ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Бие даан нэр дэвшигч иргэн Пүрэвсүрэнгийн Давхарбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн Аудит MNS 6817-1 2020 Тулгуур зарчим, төрийн аудит MNS 6817-6: 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8: 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Пүрэвсүрэнгийн Давхарбаяр бие даан нэр дэвшигч”-ийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар


зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Пүрэвсүрэнгийн Давхарбаяр бие даан нэр дэвшигч"-ийн мөрийн хөтөлбөрийг /.....хуудас/-ыг хавсаргав.

Хувийг: Орхон аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт.....хуудастай.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ